212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	00.00	00.00	00.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	00.00	00.00	00.00	00.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00	00.00	00.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	780000.00	770000.00	780000.00	780000.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	00.00	00.00	00.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00	00.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	780,000.00	770,000.00	780,000.00	780,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	00.00	00.00	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	00.00	00.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	00.00	00.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	00.00	00.00	00.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	00.00	00.00	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00	00.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	770,000.00	780,000.00	780,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	00.00	00.00	00.00

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

220001	Барилга байгууламж	00.00	00.00	00.00	00.00
221001	Их засвар	00.00	00.00	00.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	00.00	00.00	00.00
223001	Бусад хөрөнгө	00.00	00.00	00.00	00.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	00.00	00.00	00.00	00.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	00.00	00.00	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00	00.00	00.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	00.00	00.00	00.00	00.00
230001	Эргэж төлөгдөх зээл	00.00	00.00	00.00	00.00
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	00.00	00.00	00.00	00.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	00.00	00.00	00.00	00.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	701,115,500.00	698,089,338.28	799,719,700.00	799,711,406.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	644,699,100.00	642,050,070.28	733,345,800.00	733,345,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	644,699,100.00	642,050,070.28	733,345,800.00	733,345,800.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	00.00	00.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	00.00	00.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	56,416,400.00	56,039,268.00	66,373,900.00	66,365,606.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	56,416,400.00	56,039,268.00	66,373,900.00	66,365,606.00
134003	Нийгмийн даатгалын сангаас	00.00	00.00	00.00	00.00

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	эмнэлгүүдэд олгох санхүүжилт				
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	00.00	00.00	00.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
120004 4	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	00.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	00.00	00.00	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	00.00	00.00	00.00
<b>14</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	00.00	00.00	00.00
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	00.00	00.00	00.00	00.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00	00.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00	00.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>40.00</b>	<b>40.00</b>	<b>40.00</b>	<b>40.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00	00.00	00.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	39.00	39.00	39.00	39.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00	27.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	11.00	11.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	00.00	00.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	00.00	00.00	00.00	00.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	00.00	00.00	00.00	00.00

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

630001	Төрийн өмчит ЕБС	00.00	00.00	00.00	00.00
630002	Хувийн ЕБС	00.00	00.00	00.00	00.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	00.00	00.00	00.00	00.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	00.00	00.00	00.00	00.00
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	00.00	00.00	00.00	00.00
<b>632</b>	<b>МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ</b>	00.00	00.00	00.00	00.00
632001	Төрийн өмчит МСҮТ	00.00	00.00	00.00	00.00
632002	Хувийн МСҮТ	00.00	00.00	00.00	00.00
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	00.00	00.00	00.00	00.00
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	00.00	00.00	00.00	00.00
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	00.00	00.00	00.00	00.00
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо	00.00	00.00	00.00	00.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>39.00</b>	<b>39.00</b>	<b>39.00</b>	<b>39.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	00.00	00.00	00.00	00.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	00.00	00.00	00.00	00.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	00.00	00.00	00.00	00.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	00.00	00.00	00.00	00.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	00.00	00.00	00.00	00.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	00.00	00.00	00.00	00.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	00.00	00.00	00.00	00.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	27.00	27.00	27.00	27.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.00	12.00	12.00	12.00
650010	Гэрээт ажилтан	00.00	00.00	00.00	00.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	00.00	00.00	00.00	00.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах,үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 21 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ**

Хутаг-Өндөр сумын ЭМТ нь тайлант хугацаанд “Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сум дундын эмнэлгийн стандартын дагуу ээлтэй орчин бүрдүүлж чанартай үйлчилгээг үзүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлж үүний хүрээнд доорх зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлнэ.
- Эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, эргэлт хяналтыг тогтмолжуулан, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж ажиллуулна.
- Халдварт өвчний тандалт сэргийлэлт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулна.
- Сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагаанд орчин үеийн шинэлэг аргуудыг нэвтрүүлнэ.
- Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах
- Байгууллагын тохижилт соёлжилтыг нэмэгдүүлэн үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй, байгууллагын НБББББ-ийг шинэчлэн боловсруулсан байна.

#### **3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэн боловсруулжээ.

ХАК нь 2020 онд Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд баталгаажуулах аудит хийж, нийт 2232.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 132.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 100.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн хариуг 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр биелэлтийг хүргүүлэн ажиллажээ.

ХАК нь 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил илрээгүй мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж дуусгавар болсон тайланд дурдсан байна.

Мөн ХАК нь эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-д тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 451338.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9026.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон төлөвлөж, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 883827.5 мянган төгрөгийн зардлаас 2 хувиар буюу 17676.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон авч үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17958.0 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		47.4	47.4
Урьдчилгаа			
Бараа материал	26186.6	45063.6	18877.0
Үндсэн хөрөнгө	1572726.9	1571807.9	-919.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1598913.5</b>	<b>1616871.5</b>	<b>17958.0</b>
Өр төлбөр		630.9	630.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1598913.5	1616240.6	17327.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1598913.5</b>	<b>1616871.5</b>	<b>17958.0</b>

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй.

Авлага данс үлдэгдлийг 47.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тайлагнасан.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 45016.1 мянган төгрөг болж өмнөх оноос 18829.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тухайн жилд нийт 137167.3 мянган төгрөгийн бараа материал нэмэгдүүлж 118337.8 мянган төгрөгийг зарцуулсантай холбон үзэж байна.

Тухайн жилд төсвийн хөрөнгөөр 106538.7, ЭМГ-аас 16051.5, ЗДНХ-өөс 8740.0, бусад иргэн, байгууллагаас 5837.0 мянган төгрөг буюу нийт 137167.2 мянган төгрөгийн материалыг орлогод бүртгэн тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 2018336.8 мянган төгрөг болж 10261.5 мянган төгрөгөөр хасагдсан нь төсвийн хөрөнгөөр 19219.8, хандив тусламжаар 41096.0, буюу нийт 60315.8 мянган төгрөгийн хөрөнгийг нэмэгдүүлж оны эцэст 76592.4 мянган төгрөгийг акталж хасагдсантай холбон үзэж байна.

Тухайн онд элэгдлээ бүрэн нөхсөн 13742.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж хуримтлагдсан үр дүнг 6014.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнажээ.

Өр төлбөр дансны үлдэгдлийг 630.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэж хасагдсан хөрөнгөгүй байна.

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 901154.5 мянган төгрөгийн орлого байгаа нь өмнөх оноос 71635.5 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хандив тусламжийн бараа, материалын болон үндсэн хөрөнгө, цалин, эм, ашиглалтын зардлуудын өссөн үзүүлэлтийн өөрчлөлт байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 110157.7 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, эмийн зардал нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хуримтлагдсан үр дүн өмнөх оны хуримтлагдсан үр 17327.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт гарснаар тайлагнажээ.

### **3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 733345.8, ЭМДСангаас 66373.9 буюу нийт 799719.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулж санхүүжүүлэхээр улсын төсвөөс 733345.8, ЭМДСангаас 66365.6, нэмэлт санхүүжилтийн дансаар 23703.5 мянган төгрөг буюу нийт 823414.9 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 816563.1 мянган төгрөгийг зарцуулж 6851.8 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 816563.1 мянган төгрөг буюу 99.1 хувийг зарцуулж батлагдсан санхүүжилтийг бүрэн хэмжээнд зарцуулсан байна.

#### **Улсын/орон нутгийн/төсөвт төвлөрүүлэх орлого**

Өөрийн орлогыг төлөвлөөгүй болно.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр 23703.5 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 22667.5 мянган төгрөгийг зарцуулж 1036.0 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

### 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлээгүй, байгууллагын даргын тушаал шийдвэртэй холбоотой 6385.7 мянган төгрөгийн 18 тушаал шийдвэртэй холбоотой мэдээллийг мэдээлж ажиллаагүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 2232.9 мянган төгрөгийн зөрчлөөс 132.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 2000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 100.9 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг тус тус биелүүлсэн байна.

Нийт 2232.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 132.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 100.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 3: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мян/төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	132.0	1	132.0			
Албан шаардлага	1	2000.0	1	2000.0			
Зөвлөмж	3	100.9	3	100.9			
Нийт дүн	5	2232.9	5	2232.9			

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13090.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 134.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 5404.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар 7552.2 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч ажиллалаа.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 19219.8 мянган төгрөгийн алдаатай бичилтийг залруулж ажиллалаа.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 5538.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 134.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоон, 5404.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Тус сумын ЭМТ-ийн томилолтын зарцуулалтыг түүвэрлэн шалгахад томилолтын хуудасгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, томилолтын хоног илүү тооцож 98000 төгрөгийг олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын ЭМТ-ийн шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад 36000 төгрөгийн шатахууны орлогыг орлогод авч тайлагнаагүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

3. Тус сумын ЭМТ нь аймгийн ЭМГ-аас хандиваар 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 13, 15, 17 тоот дугаартай зарлагын баримтаар олгосон 5404668 төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг орлогод авч тайлагнаагүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” “Эд хариуцагчийн хүлээх үүрэгт “Ажиллаж байгаа байгууллагынхаа дотоод дүрэмд захирагдаж өөрийн гүйцэтгэх ажил үүрэг, сар, улирал, жилийн төлөвлөгөөт ажлыг цаг хугацаанд нь биелүүлж удирдлагад тайлагнаж мэдээллээр ханган тэдэнтэй байнга хамтран ажиллана”, “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар эмийн орлого зардлыг гүйцэтгэлтэй түүвэрлэн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тухайн байгууллагын эмийн зардлаас хоолны зардал шилжүүлэх, эмийн орлогыг дутуу тусгасан асуудлууд анхаарал татахуйц байна.

**4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтын анхан шатны баримт дутуу, даргын цохолтоор болон шаардах хуудсаар олгож байгаа боловч нярваар дамжуулж шатахуун олгодоггүй зөрчил илэрлээ.

1.2 Эрсдэл: Төсөвт зарцуулах хяналт сулрах

1.3 Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 13.6, 13.7 дахь заалтыг мөрдөж ажиллах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Няраваар дамжуулан шатахууныг олгож баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллана.

2. Зардал данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа тендерт шалгарсан компаниас худалдан авалт хийгээгүй, тендерт шалгараагүй компаниас 582.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил илэрлээ.

2.2 Эрсдэл: Холбогдох хууль журам зөрчигдөх

2.3 Өгсөн зөвлөмж: Тухайн жилд эмийн тендерт шалгарсан компаниас худалдан авалт хийх, мөн ЭМГ-ийн зөвлөмжийг мөрдөж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тендерийн бус компаниас эм худалдан авахгүй ажиллана.

3. Зардал данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Эмийн зардлаас хоолны зардалд 583.6 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

3.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр төлбөр үүсэх

3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг мөрдөж төсвийг оновчтой төлөвлөн батлуулж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зардал хооронд шилжүүлэхгүй тухайн зардалд багтаан ажиллана.

4. Хууль журамтай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Байгууллагын төсөв хөрөнгөтэй холбоотой 6385.7 мянган төгрөгийн 18 тушаал шийдвэрийг цаг хугацаанд нь шилэн дансны мэдээлэлд мэдээлж ажиллаагүй байна.

4.2 Эрсдэл: Хууль журам зөрчигдөх

4.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар заалтыг мөрдөж цаг хугацаанд нь мэдээлж ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Шилэн дансны мэдээллийг ханган ажиллана.

Дээрх 4 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хутаг-Өндөр сумын ЭМТ	Аудитын код:
2020			САГ-2021/130/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймаг дахь Төрийн аудитын газар		Мянган төгрөг

Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Томилолтын хуудасгүй, томилолтын хоног илүү тооцож томилолтын зардал олгосон.	98.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Н.Эрдэнэчимэг, П.Уранчимэг
2	Шатахууны орлогыг нярвын шатахууны тайланд орлого авч тайлагнаагүй.	36.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Н.Эрдэнэчимэг, П.Уранчимэг
3	ЭМГ-аас үнэ төлбөргүй хандиваар олгосон эм эмнэлгийн хэрэгслийн материалыг орлого авч тайлагнаагүй байна.	5404.7	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Н.Эрдэнэчимэг, П.Уранчимэг
4	Шатахуун зарцуулалт анхан шатны баримт дутуу, даргын цохолтоор шаардах хуудсаар нярваар дамжуулж шатахууныг олгоогүй байна.	0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Н.Эрдэнэчимэг, П.Уранчимэг
5	Эмийн зардлаас хоол хүнсний зардалд шилжүүлэн зарцуулсан.	583.6	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Н.Эрдэнэчимэг, П.Уранчимэг
6	Тендерт шалгараагүй компаниас эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байна.	582.9	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Н.Эрдэнэчимэг, П.Уранчимэг
7	Байгууллагын төсөв хөрөнгөтэй холбоотой 6385746 төгрөгийн 18 тушаалыг шилэн дансанд мэдээлээгүй зөрчил илэрлээ.	6385.7	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Н.Эрдэнэчимэг, П.Уранчимэг
<b>ДҮН</b>		<b>13090.9</b>			

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР  
 МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:  
 АХЛАХ АУДИТОР П.МӨНХТУЯА

